



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
ЭХ, НЯРАЙ, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ ХОЁР-ЫН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/52

Улаанбаатар хот

Журам, шалгуур үзүүлэлт
шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, Засгийн газрын 2019 оны 395 дугаар тогтоолын 3.2 дугаар заалт, Төвийн дүрэм, бүтэц, орон тоо батлах тухай Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/529 дүгээр тушаалын 4.7.6, байгууллагын Хөдөлмөрийн дотоод журмын 14.3.4 дэх хэсэг, Удирдлагын зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журмыг нэгдүгээр, удирдах ажилтныг үнэлэх шалгуур үзүүлэлтийг хоёрдугаар, эмч эмнэлгийн мэргэжилтний үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг гуравдугаар, эмнэлгийн бусад ажилтны үр дүнг үнэлэх шалгуур үзүүлэлтийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг нийт албан хаагчдад танилцуулж, мөрдөж ажиллахыг дэд захирал, албаны дарга, тасгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.
3. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн дэд захирал (Ц.Тулга)-д, Захиргаа, хүний нөөцийн алба (Б.Отгончимэг)-д тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захирлын ажлын алба (Н.Тунгалаг)-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2021 оны А/92 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



А.ЭРДЭНЭТУЯА

Ерөнхий захирлын 2022 оны
04 дугаар сарын 07-ны өдрийн
А/52 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЛБАН ХААГЧДАД МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү журмыг Эх нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв II-ийн ажилтнуудад ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгоход мөрдөнө.

1.2. Мөнгөн урамшууллыг холбогдох хууль, Засгийн газрын тогтоол, төвийн Хөдөлмөрийн дотоод журмын заалтыг үндэслэн, энэхүү тушаалаар баталсан шалгуур үзүүлэлтийн дагуу сар бүр дүгнэж, түүнийг үндэслэн, шалгуур хангасан ажилтанд мөнгөн урамшууллыг улиралд үндсэн цалингийн 60 хүртэл хувиар тооцож, нэг удаа олгоно.

ХОЁР. УРАМШУУЛАЛ ОЛГОГДОХ ҮНДСЭН НӨХЦӨЛҮҮД

2.1. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан нь ажил олгогчтой хөдөлмөрийн гэрээ байгуулсан байгууллагын үндсэн ажилтан байна.

2.2. Хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.

ГУРАВ. УРАМШУУЛАЛ ОЛГОГДОХГҮЙ БАЙХ ҮНДСЭН НӨХЦӨЛҮҮД

3.1. Доорх тохиолдолд эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтанд урамшуулал олгохгүй.

3.1.1. Мэргэшил эзэмших болон мэргэжил дээшлүүлэх гадаад, дотоодын сургалтанд хамрагдсан хугацаанд

3.1.2. Эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан ээлжийн амралтын хугацаанд

3.1.3. Ерөнхий захирлын тушаалаар сахилгын шийтгэл авсан бол сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жилийн хугацаанд

3.1.4. Тайлант сард эмнэлгийн тусламж үйлчилгээний зөрчил гаргасан нь батлагдсан тохиолдолд

3.1.5. Тайлант сард эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтантай холбоотой ёс зүйн хэм хэмжээний зөрчил, гомдол гаргасан нь батлагдсан тохиолдолд

3.1.6. Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан нь эмнэлгийн нөхцөлд ажлын байран дээр хувцаслах хэм хэмжээг мөрдөөгүй

3.1.7. Тухайн сард ажил тасалсан, ажлын цагийн хоцрогдолтой, өвчтэй, чөлөөтэй байсан

3.1.8. Эмнэлгийн захиргаа, алба, тасгийн эрхлэгчээс тухайн сард төлөвлөгдсөн болон ажлын шаардлагаар яаралтай өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй

3.1.9. Байгууллагад хийгдсэн хяналт үнэлгээгээр зөрчил гаргасан нь тогтоогдсон

3.1.10. Туршилтын болон хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллуулах хугацаанд урамшуулал олгохгүй.

3.1.11. Ажлын үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг 71-ээс доош хувьтай байгаа тохиолдолд тухайн албан хаагчид улирлын урамшуулал олгохгүй.

ДӨРӨВ. САР БҮР АЖЛЫН ҮР ДҮНГ ДҮГНЭХ АЛБАН ТУШААЛТАН

- 4.1. Ерөнхий захирал нь удирдлагын зөвлөлийн гишүүдийн ажлыг үнэлнэ.
- 4.2. Дэд захирлууд нь өөрийн харьяалагдах албадын дарга, тасгийн эрхлэгч нарын ажлын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, гүйцэтгэлийн үнэлгээнд хяналт тавьж, хурлын тэмдэглэлийг баталгаажуулан Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын албанд хүргүүлнэ.
- 4.3. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, чанар аюулгүй байдлын алба нь бүх алба тасгийн гүйцэтгэлийн тайлангийн үнэлгээг нэгтгэн Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 4.4. Албаны дарга, тасгийн эрхлэгч нар нь өөрсдийн харъяанд ажиллаж байгаа нэгжийн эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын ажлын үр дүнг сар бүр батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, үнэлгээг хамт олны хурлын тэмдэглэлийн хамт сар, улирал бүрийн дараа сарын 6-ны дотор харъяалах дэд захиралд ирүүлнэ.

ТАВ. САР БҮРИЙН АЖЛЫН ҮР ДҮНГ ДҮГНЭХ НЭГДСЭН АРГАЧЛАЛ

- 5.1. Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлж, шаардлага хангасан тохиолдолд улирал тутам батлагдсан төсөвт багтаан зохих суутгалуудыг суутган тооцож олгоно.
- 5.2. Эмнэлгийн мэргэжилтэн эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн болон үр дүнгийн үнэлгээг :
- “Бүрэн хангалттай А”- 90-100оноо
 - “Хангалттай Б”- 71-89 оноо
 - “Хангалтгүй” – 70 ба түүнээс доош оноо гэсэн үнэлгээгээр сар бүр дүгнэнэ.

Ажлын үр дүнгийн үнэлгээ

Засгийн газрын тогтоолоор баталсан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүнг сар бүр үнэлэх ба үнэлгээний нийт хувиас хамаарч, дараах хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшууллын хэмжээг тооцно.

№	Ажлын гүйцэтгэл, чанар, үр дүн, ёс зүйн хэм хэмжээний нэгдсэн дүн /хувь/	Урамшуулал олгох хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ
1	70-аас доош	0	Хангалтгүй
2	71 – 74	5%	Хангалттай
3	75 – 79	6%	
4	80 – 85	8%	
5	86 – 89	10%	
6	90 – 92	12%	Бүрэн хангалттай
7	93 – 94	14%	
8	95 – 96	16%	
9	97 – 98	18%	
10	99 – 100	20%	

ЗУРГАА. АЖЛЫН ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ, ОЛГОХ

6.1. Дэд захирлууд нь журмын хавсралтад заасан шалгуурын үнэлгээнд хяналт тавьж, холбогдох албан тушаалтнуудаар дараа улирлын эхний сарын 06-аас 08-ны өдрүүдэд баталгаажуулалт хийлгэнэ. (Дараа улирлын эхний сарын 06-аас 08-ны өдрүүд нь амралтын өдөр таарвал өмнөх ажлын өдөрт нь өгнө)

6.2. Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн ажилтны сарын ажлын үр дүнгийн үнэлгээг, алба, тасгийн хамт олны хурлын тэмдэглэл, дэд захирлын саналын хамт Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албанаас Удирдлагын зөвлөлийн хурлаар оруулж шийдвэрлүүлсний дараа шийдвэрийг үндэслэн Захиргаа, хүний нөөцийн алба Ерөнхий захирлын тушаалын төслийг боловсруулан батлуулна.

6.3. Мөнгөн урамшууллыг дараа улирлын эхний сарын 25-ны дотор олгоно.

Мөнгөн урамшууллын хувь хэмжээ

Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран урамшууллын хувь хэмжээг дараах байдлаар олгоно.

Бүх шалгуурын биелэлтийн хувь	Ажлын үр дүнгийн үнэлгээ	Олгох урамшууллын хувь
90-100	Бүрэн хангалттай	15 – 20 хувь
71-89	Хангалттай	7 -14 хувь
70 ба түүнээс доош	Хангалтгүй	Урамшуулал олгохгүй

ДОЛОО. ХЯНАЛТ

7.1. Эрүүл мэндийн ажилтны ажлын үр дүн, үнэлгээнд тасгийн эрхлэгч, албаны дарга, ахлах сувилагч нар хяналт тавина.

7.2. Тасгийн эрхлэгч, албаны даргын ажлын үр дүнгийн үнэлгээнд дэд захирлууд хяналт тавина.

7.3. Дэд захирлууд, Захиргаа, хүний нөөцийн албаны дарга, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга, Хяналт шинжилгээ дотоод аудитын ажилтны ажлын үр дүнгийн үнэлгээнд Ерөнхий захирал хяналт тавина.

НАЙМ. ХАРИУЦЛАГА

8.1. Товлосон хугацаанд хамт олны хурлаар хэлэлцүүлсэн дүгнэлтийг дараа улирлын эхний сарын 05-ны дотор өгөөгүй, 08-ны дотор хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр баталгаажилт хийгээгүй тохиолдолд албан тушаалтны болон тухайн хамт олны мөнгөн урамшууллыг маргах нөхцөлгүйгээр хасч хариуцлага хүлээлгэнэ.

8.2. Эрх бүхий албан тушаалтны гаргаж өгсөн оноог санаатай болон санамсаргүй байдлаар зассан ажилтан, албан тушаалтны мөнгөн урамшууллаас маргах нөхцөлгүйгээр хасч, хариуцлага хүлээлгэнэ.


Ерөнхий захирлын 2022 оны
 04 дугаар сарын 07-ны өдрийн
 4/52 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

№	Үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Хувь
9020110453 ٩٠٢٠١١٠٤٥٣			
I. Нийтлэг шалгуур			
1	Үйлчилгээний чанар	1. Хүлээгдэл чирэгдэлгүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдал	5
2		2. Ёс зүй, харилцаа хандлага	20
3		3. Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал	5
4	Ажлын ачаалал, хариуцлага	1. Ажлын цаг ашиглалт	5
5		2. Ажлын ачаалал	5
6		3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт	5
7		4. Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	5
8	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	1. Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал	5
9		2. Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал	5
10		3. Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	5
II. Тусгай шалгуур			
11	Удирдлага, зохион байгуулалт	1. Холбогдох хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт	10
12		2. Төлөвлөгөөний биелэлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	5
13		3. Ажил мэргэжлийн ур чадвар, удирдан зохион байгуулах чадвар	10
14		4. Бичиг баримт, байгууллагын нууцлалын байдал	5
15		5. Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар	5
Нийт			100

Ерөнхий захирлын 2022 оны
 04 дугаар сарын 07-ны өдрийн
 4/52 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

№	Үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Хувь
I. Нийтлэг шалгуур			
1	Үйлчилгээний чанар	1. Хүлээгдэл чирэгдэлгүй тусламж, үйлчилгээ үзүүлсэн байдал	5
2		2. Ёс зүй, харилцаа хандлага	20
3		3. Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал	5
4	Ажлын ачаалал, хариуцлага	1. Ажлын цаг ашиглалт	5
5		2. Ажлын ачаалал	5
6		3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт	5
7		4. Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	5
8	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	1. Эмчилгээ үйлчилгээнд шинэ бүтээл, оновчтой санааг нэвтрүүлэн, эдийн засгийн үр өгөөжийг тооцсон байдал	5
9		2. Үргүй зардлыг багасгах талаар тодорхой санал санаачилга гарган ажилласан байдал	5
10		3. Ажлын идэвх, олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	5
II. Тусгай шалгуур			
11	Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар	1. Эмчилгээ, үйлчилгээний стандартыг мөрдөж байгаа байдал	10
12		2. Халдвар хамгааллын дэглэмийг мөрдөж байгаа байдал	5
13		3. Эмчилгээ, үйлчилгээний талаар гомдол гаргасан байдал	10
14		4. Үйлчлүүлэгчид зөвлөгөө өгсөн байдал	5
15		5. Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар	5
Нийт			100

Ерөнхий захирлын 2022 оны
 0.1... дугаар сарын 07...-ны өдрийн
 4/52 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



№	Үндсэн шалгуур	Үндсэн шалгуурыг тодорхойлох тусгай үзүүлэлт	Хувь
I. Нийтлэг шалгуур			
1	Үйлчилгээний чанар	1. Хүлээгдэл чирэгдэлгүй үйлчилгээ үзүүлсэн байдал /хариуцсан ажил үүргийн ур чадвар/	5
2		2. Ёс зүй, харилцаа хандлага	20
3		3. Үйлчлүүлэгч, хамт олны сэтгэл ханамжийн байдал	5
4	Ажлын ачаалал, хариуцлага	1. Ажлын цаг ашиглалт	10
5		2. Ажлын ачаалал	5
6		3. Хариуцсан өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалт	5
7		4. Албан хэргийн бүртгэл, хөтлөлт, тайланг хугацаанд нь гаргасан байдал	5
8	Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд оруулсан хувь нэмэр	1. Үйлчилгээнд оновчтой санал санаачилга нэвтрүүлэн идэвх чармайлт гарган ажилласан байдал	10
9		2. Олон нийтийн арга хэмжээнд оролцсон байдал	5
II. Тусгай шалгуур			
10	Хариуцсан ажлын чанар	1. Стандарт мөрдөж байгаа байдал	10
11		2. Үр дүнгийн гэрээ, ажлын байрны тодорхойлолтод заасан ажлын гүйцэтгэл, чанар	15
12		3. Удирдлагын зүгээс өгсөн үүрэг даалгаврын биелэлт	5
Нийт			100